



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/10

Мөрөн сум

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт ерөнхий боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хэрэгжилтийг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Базар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Ц.Ганзориг	(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
П.Галсандорж	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
Б.Баярмөнх	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
О.Бадраа	(Мөрөн сумын Эрдмийн далай лаборатори сургуулийн захирал)
Д.Даваадорж	(Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)
С.Тайванжаргал	(Их-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
Л.Батжаргал	(Мөрөн сумын ерөнхий боловсролын "Сод-Эрдэм" сургуулийн нягтлан бодогч)
О.Мөнхболд	(Мөрөн сумын хүүхдийн I цэцэрлэгийн нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга:

Н.Далайжаргал (Боловсрол, шинжлэх ухааны газрын Ахлах мэргэжилтэн)

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны ажлын хэсгээс өгсөн чиглэл, удирдамжийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж, ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

